

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ ЭРХЛЭХ ИРГЭНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР.

БАРИМТ БИЧИГ

- Өргөдөл /Овог нэр, регистр, хаяг, одоо ашиглаж буй утасны дугаар, И-мэйл хаяг, хаана байрших хүсэлтэй байгаа талаар дэлгэрэнгүй бичих/
- Иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
- ТҮЦ-ийн хэмжээ, зураг
- Ажилчны эрүүл мэндийн шинжилгээний дэвтэр

Хугацаа:

- Хүсэлтийг 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 13-ны өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авна.
- Ажлын хэсэг баримт бичгийг магадлан шалгаж, сонгон шалгаруулалтыг үе шаттай зохион байгуулна.
- Сонгон шалгаруулалтын дүнг нийтэд ил тод мэдээлнэ.

Тавигдах шаардлага:

- Дүүргийн иргэн байх.
- ТҮЦ нь 20 метр квадратаас дээшгүй, өнгө үзэмжтэй байх.
- Дүүргээс санал болгосон байршил болон авто зам, явган зорчигчын хөдөлгөөнд саад учруулахгүй байх.
- Дотор талбайн 50-иас доошгүй хувийг иргэдэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэхээр тохижуулах.
- Ажилчид эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан, мэргэжлийн үнэмлэхтэй, зориулалтын хувцас хэрэгсэлтэй байх.
- Ариун цэврийн өрөөгөөр хангагдах нөхцлийг бүрдүүлж, гар угааж, халдваргүйжүүлэх хэсэгтэй байх.
- Орчныхоо цэвэрлэгээг бүрэн хариуцаж, зориулалтын хогийн сав байрлуулан, хог хаягдал ачиж тээвэрлүүлэх гэрээ байгуулах.
- Татвар төлөгчөөр бүртгүүлж, татварын системд холбогдсон, кассын төхөөрөмжөөр төлбөр тооцоог хийж, үйлчлүүлэгчдэд төлбөрийн баримт олгодог, тайлан мэдээг хуулийн дагуу гаргаж, тайлагнадаг байх.
- Хэрэглэгчийн гомдол саналыг хүлээн авах хайрцаг байршуулж, шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авдаг байх.
- Шаардлагатай үед, нэг байршилд олон иргэний хүсэлт давхардвал хорооноос өмнө нь ТҮЦ эрхэлж байсан талаарх тодорхойлолт авах.



..... ДҮҮРЭГТ ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ ЭРХЛЭХЭД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2026 оны сарын-ны өдөр

№

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү гэрээг Хүнсний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 25/29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх үүргийг тодорхойлсон нийтлэг журам”-ыг үндэслэн Нэг талаас..... дүүргийн Засаг даргын Тамгын газар Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга /цаашид “А” тал гэх/, Нөгөө талаас овогтой РД /цаашид “Б” тал гэх/ нар доорхи нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2.Гэрээг оны дугаар сарын-ны өдрөөс оны дугаар сарын-ны хугацаанд байгуулав.

1.3.Түргэн үйлчилгээний цэгийг дүүргийн дугаар хорооны уртраг, өргөрөгт байршуулахаар тохиролцов.

Хоёр. А талын хүлээх эрх, үүрэг

2.1.Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, хэрэгжилтийг хангуулахаар үүрэг даалгавар өгөх, холбогдох хууль, тогтоомжийг биелүүлэхийг шаардах;

2.2.Иргэдээс ирсэн хүсэлт, гомдол, төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөмж, мэдэгдэл хүргүүлэх, **2 ба түүнээс дээш** зөрчил гаргасан нь баримтаар нотлогдвол гэрээг цуцлах хүртэлх арга хэмжээ авах;

2.3.Энэхүү гэрээний хэрэгжилтэд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтэс, дүүрэг дэх Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, хороодын Засаг дарга нар хяналт тавьж ажиллана.

2.4.“Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх үүргийг тодорхойлсон нийтлэг журам”-ын 3.6 дахь хэсэгт заасны дагуу байршил батлах;

Гурав. Түргэн үйлчилгээний цэг эзэмшигчийн хүлээх үүрэг

3.1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” А/847 дугаар

АНХААРАХ ЗААЛТУУД:

- Заасан байршилд дүүргийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.
- Хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч болон түргэн муудаж гэмтдэг бараа бүтээгдэхүүн, худалдаалахыг хориглоно.
- Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу энгийн болон тусгай зөвшөөрөл (тамхи, согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх) олгодог үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.
- Түргэн үйлчилгээний цэгийг аж ахуйн нэгж, иргэдэд давхар түрээслэхийг хориглоно.
- Нийслэл, дүүргээс тухайн газарт төлөвлөлтийн хүрээнд тохижилтын ажил хийгдэх тохиолдолд газрыг үл маргах журмаар чөлөөлөх буюу дүүрэг дараагийн байршил санал болгоно.
- Гэрээг иргэдээс ирүүлж буй хүсэлт, гомдол, түргэн үйлчилгээний цэг эрхлэгч гэрээний нөхцлийг биелүүлсэн эсэхийг үндэслэн гэрээг 1 жилээр сунгах эсэхийг шийдвэрлэнэ.